



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/301

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймагт зохион байгуулагдах Монгол Улсын гавьяат тамирчин Равдангийн Даваадалайгийн нэрэмжит өсвөрийн Жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээний арга хэмжээнд 25,0 сая төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Уг арга хэмжээнд зарцуулах 25,0 сая төгрөг /Хорин таван сая/ -ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээний 5.17-д заасан "Спортын аварга" хөтөлбөрөөс тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Тэмцээнийг өндөр хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Биеийн тамир спортын газрын дарга /Г.Цэдэнбал/, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар  
сарын 13-ны өдрийн А/301 дүгээр  
захирамжийн хавсралт



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БАРУУН БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БҮЙ  
"ХОВД-2019" ӨСВӨРИЙН ЖҮДО БӨХИЙН УЛСЫН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Байр	Хүн /тоо хэмжээ/	Ажил-лах хоног	Нэг бүрийн үнэ /Шагнал/	Нийт шагнал	Суутгал	Олгох дүн
1 дүгээр байр /Эрэгтэй/	багийн дүнгээр		600,000	600,000	30,000	570,000
2 дугаар байр /Эрэгтэй/	багийн дүнгээр		500,000	500,000	25,000	475,000
3 дугаар байр /Эрэгтэй/	багийн дүнгээр		400,000	400,000	20,000	380,000
1 дүгээр байр /Эмэгтэй/	багийн дүнгээр		600,000	600,000	30,000	570,000
2 дугаар байр /Эмэгтэй	багийн дүнгээр		500,000	500,000	25,000	475,000
3 дугаар /Эмэгтэй/	багийн дүнгээр		400,000	400,000	20,000	380,000
Тамирчдад олгох мөнгөн шагнал	30		40,000	1,200,000	60,000	1,140,000
Тамирчдад олгох мөнгөн шагнал	30		30,000	900,000	45,000	855,000
Тамирчдад олгох мөнгөн шагнал	60		20,000	1,200,000	60,000	1,140,000
Шүүгчдийн хөлс	15	4	50,000	3,000,000	300,000	2,700,000

Шүүгчдийн байр	15	5	30,000	2,250,000	225,000	2,025,000
Шилдэг тамирчин	2		50,000	100,000	5,000	95,000
Шилдгийн шилдэг тамирчин	2		100,000	200,000	10,000	190,000
Шилдэг шүүгч	1		100,000	100,000	5,000	95,000
Тамирчдын бэлтгэлийн хувцас	60		95,000	5,700,000		5,700,000
Тамирчдын хоол хүнс	60	2019.05.01-2019.05.17	83,333	5,000,000		5,000,000
Өргөмжлөл /том/	6		50,000	300,000	-	300,000
Өргөмжлөл /Жижиг/	126		5,000	630,000		630,000
Шилдэг тамирчин өргөмжлөл	8		5,000	40,000		40,000
Аннос	2		120,000	240,000		240,000
Дэвжээ /Бэлтгэл тээвэрлэлт, хэрэглэгдэх материал г.м/ засах ажил,		5	1,140,000	1,140,000		1,140,000
Нийт дүн			4,918,333	25,000,000	860,000	24,140,000